



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 10 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг
эрчимжүүлэх тухай

Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Зам, тээврийн хөгжлийн сайдын Зөвлөлийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор холбогдох албан тушаалтан, албан хаагчдад дараах албан даалгаврыг өгч байна. Үүнд:

Нэг. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр:

1.1 Нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанаас гаргасан хэрэгжээгүй 14 зөвлөмжийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөрт багтаан хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулж ажиллахыг Нислэг-техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т үүрэг болгов.

1.2. Төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийг тоон үзүүлэлтээр гаргаж улирал тутам тайлагнаж ажиллах, шаардлагатай тохиолдолд албаны дүрэм, холбогдох журамд өөрчлөлт оруулах ажлыг 2020 онд багтаан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах, зөвлөмжийн хэрэгжилтэд хариуцлагагүй хандсан байгууллагын удирдлагын талаар тухай бүр мэдээлж ажиллахыг Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /Ж.Цолмон/-нд үүрэг болгов.

1.3. Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны зөвлөмжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т даалгав.

1.4. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллагаанд хайхрамжгүй хандсан, хэрэгжүүлээгүй хугацаа хэтрүүлсэн, агаарын хөлгийн осол зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Болор-Эрдэнэ/, Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-т тус тус даалгав.

1.5. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ажлын гол үзүүлэлт болгон тусгаж, хэрэгжилтийг дүгнэж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгов.

Хоёр. Албан даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/-т үүрэг болгов.

Гурав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т даалгав.

